



Үндэсний статистикийн
хороо

2019.6

Сарын танилцуулга



ИНФЛЯЦ, ҮНИЙН ӨӨРЧЛӨЛТ



АГУУЛГА

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ.....	2
ЗУРГИЙН ЖАГСААЛТ.....	3
ОРШИЛ.....	4
ИНФЛЯЦ.....	5

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Инфляцын бүлгүүдийн оролцооны түвшин, жил бүрийн 6 дугаар сард	5
Хүснэгт 2. Инфляцын импортын барааны оролцооны түвшин, жил бүрийн 6 дугаар сард.....	6
Хүснэгт 3. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, хувиар, 2019 оны 6 дугаар сард.....	7
Хүснэгт 4. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, бараа, үйлчилгээний бүлгээр, улс, бүсээр, хувиар, 6 дугаар сард.....	8
Хүснэгт 5. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, өмнөх оны мөн үетэй харьцуулснаар, хувиар, жил бүрийн 6 дугаар сард.....	9

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Инфляцын бүлгүүдийн оролцооны түвшин, 2016-2019 он, жил бүрийн 6 дугаар сард.....	6
Зураг 2. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс (өмнөх оны 12 дугаар сар =100%), хувь.....	8
Зураг 3. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, хувь, аймаг, нийслэлээр, 2019 оны 6 дугаар сард (өмнөх сар=100%).....	10
Зураг 4. Мах, махан бүтээгдэхүүний үнийн улсын индекс, хувь, (өмнөх оны 12 дугаар сар = 100%).....	11
Зураг 5. Мах, махан бүтээгдэхүүний оролцооны түвшин, 2019 оны 6 дугаар сард.....	11
Зураг 6. Улаанбаатар хотод зарагдаж буй үхрийн цул махны дундаж үнэ, сараар, төгрөгөөр.....	12
Зураг 7. Улаанбаатар хотод зарагдаж буй үхрийн ястай махны дундаж үнэ, сараар, төгрөгөөр.....	12
Зураг 8. Улаанбаатар хотод зарагдаж буй хонины ястай махны дундаж үнэ, сараар, төгрөгөөр.....	12
Зураг 9. Бензин, түлшний үнийн индекс, хувь, 2016-2019 он (өмнөх оны 12 сар=100%).....	13
Зураг 10. Улаанбаатар хотод зарагдаж АИ-92 бензиний дундаж үнэ, сараар, төгрөгөөр.....	13

ОРШИЛ

Инфляцыг хэмжих хэд хэдэн арга байдгийн нэг нь хэрэглээний үнийн индекс юм. Инфляцын түвшинг тодорхойлох, төрөөс санхүү, мөнгө зээлийн бодлогыг хэрэгжүүлэх, хүн амын цалин, тэтгэвэр, тэтгэмж бусад орлогын хэмжээг индексжүүлэх тооцооны гол үзүүлэлт нь хэрэглээний үнийн индекс болдог. Түүнчлэн хэрэглээний үнийн индексийг макро эдийн засгийн гол үзүүлэлтүүдийн нэг болох дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн аргын тооцоонд болон эцсийн ашиглалтын тооцоог зэрэгцүүлэх үнэд шилжүүлэхэд ашиглана.

Үндэсний Статистикийн Хороо нь өөрийн чиг үүргийн хүрээнд өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн мэдээллийг сар бүр цуглуулж, хэрэглээний үнийн индексийг тооцон олон нийтийн хүртээл болгож байна.

Үндэсний Статистикийн Хороо 1991 оноос Олон Улсын Валютын Сангийн аргачлалаар хэрэглээний үнийн индексийг тооцож эхэлсэн ба түүнээс хойш суурь, сагс, жинг 1995, 2000, 2005, 2010, 2015 онуудад шинэчилсэн. 1991-2006 он хүртэл Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индексээр хэрэглээний үнийн улсын индексийг төлөөлүүлэн тооцдог байсан. 1997 оноос аймгуудын индексийг тусад нь тооцож, зарлаж ирсэн.

Манай улсын нутаг дэвсгэр, газар зүйн байршлаас хамаарч, бараа, үйлчилгээний үнэ, тариф аймгуудад харилцан адилгүй, улсын хэмжээний нийт өрхийн талаас илүү хувь нь аймаг, орон нутагт амьдардаг зэргээс шалтгаалан хэрэглээний үнийн улсын индексийн тооцоонд аймгийн хэрэглээний үнийн индексийг оруулах шаардлагатай болсон. 2006 оны 1 дугаар сараас эхлэн хэрэглээний үнийн улсын индексийг Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индексээр тооцож байсан аргачлалаа шинэчилж, олон улсын аргачлалын дагуу улсын индексийг аймаг, нийслэлийн өрхийн хэрэглээний зардлаар жигнэсэн дундаж үзүүлэлтээр тооцох аргачлалд шилжсэн.

2017 оны 4 дүгээр сараас эхлэн хэрэглээний үнийн индексийг 2015 суурьт шилжүүлэн хувийн зориулалттай хэрэглээний бараа, үйлчилгээний ангиллын /ХЗХБҮА/ үндсэн 12 бүлгийн дагуу 373 (Улаанбаатар хотод 344, аймгуудад 238 нэр төрөл) нэр төрлийн бараа, үйлчилгээгээр хэрэглээний үнийн индексийг тооцож байна.

ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС

Инфляц


Инфляцын түвшин 2016 оны 6 дугаар сард 1.2 хувь, 2017 оны 6 дугаар сард 3.4 хувь, 2018 оны 6 дугаар сард 7.2 хувьтай байсан бол 2019 оны 6 дугаар сард 8.1 хувь болж өмнөх оноос 0.9 пунктээр нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Инфляцын бүлгүүдийн оролцооны түвшин, жил бүрийн 6 дугаар сард

Бараа, үйлчилгээний бүлэг	Жин	2016 VI	2017 VI	2018 VI	2019 VI
Ерөнхий индекс	100	1.2	3.4	7.2	8.1
Хүнсний бараа, ундаа, ус	26.1	-0.1	0.2	2.8	2.9
Согтууруулах ундаа, тамхи	4.4	0.1	0.1	0.4	0.2
Хувцас, бөс бараа, гутал	16.6	0.4	0.4	0.4	1.6
Орон сууц, ус, цахилгаан, түлш	9.3	-0.1	0.3	1.3	0.8
Гэр ахуйн тавилга, бараа	4.9	0.1	0.2	0.3	0.2
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	3.6	0.1	0.2	0.4	0.3
Тээвэр	14.4	-0.4	1.4	0.7	0.7
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.4	0.0	0.0	0.0	0.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	3.1	0.1	0.0	0.2	0.5
Боловсролын үйлчилгээ	4.8	1.0	0.2	0.3	0.3
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	3.0	0.0	0.0	0.2	0.3
Бусад бараа, үйлчилгээ	5.4	0.0	0.4	0.3	0.3

Инфляц 2019 оны 6 дугаар сард улсын хэмжээнд 8.1 хувьтай гарлаа. Үүнийг бүлгүүдийн оролцооны түвшингээр авч үзвэл 2.9 нэгж буюу (35.5 хувь) нь хүнсний бараа, ундаа, усны бүлгээс, 1.6 нэгж буюу (19.2 хувь) нь хувцас, бөс бараа, гутлын бүлгээс, 0.8 нэгж буюу (10.5 хувь) нь орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнийн өсөлтөөс шалтгаалсан байна. 2018 оны 6 дугаар сард хүнсний бараа, ундаа, усны бүлэг инфляцад 38.6 хувиар нөлөөлж байсан бол 2019 оны 6 дугаар сард 35.5 хувь болж 3.1 пунктээр буурсан байна.

Зураг 1. Инфляцын бүлгүүдийн оролцооны түвшин, жил бүрийн 6 дугаар сард



Хүснэгт 2. Инфляцын импортын барааны оролцооны түвшин, жил бүрийн 6 дугаар сард

Үзүүлэлт	2016 VI		2017 VI		2018 VI		2019 VI	
	Пункт	Хувь	Пункт	Хувь	Пункт	Хувь	Пункт	Хувь
Ерөнхий индекс	1.2	100.0	3.4	100.0	7.2	100.0	8.1	100.0
Импортын барааны нөлөө	0.4	37.1	2.2	64.5	2.6	35.5	2.9	35.5

Хэрэглээний бараа, үйлчилгээний сагсанд нийт 373 нэр төрлийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ, Улаанбаатар хотын хэмжээнд 344 нэр төрлийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийг судалдаг. Нийт 373 нэр төрлийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний 200 нь импортын бараа, бүтээгдэхүүн байдаг бөгөөд энэ нь нийт жингийн 45.5 хувийг эзэлдэг.

2019 оны 6 дугаар сард инфляц 8.1 хувь гарсны 2.9 нэгж буюу 35.5 хувь нь импортын барааны үнийн өсөлтөөс шалтгаалсан байна. Энэ нь 2018 оны 6 дугаар сартай харьцуулахад нөлөөлөл нь адил байна.

Хүснэгт 3. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, хувиар, 2019 оны 6 дугаар сард


Бараа, үйлчилгээний бүлэг	Жин	<u>2019 VI</u> 2018 V	<u>2019 VI</u> 2018 XII	<u>2019 VI</u> 2019 V
Ерөнхий индекс	100.0	108.1	104.9	100.7
Хүнсний бараа, ундаа, ус	26.1	110.8	114.8	100.6
Согтууруулах ундаа, тамхи	4.4	103.8	102.2	100.2
Хувцас, бөс бараа, гутал	16.6	109.8	103.6	100.7
Орон сууц, ус, цахилгаан, түлш	9.3	108.8	98.6	100.3
Гэр ахуйн тавилга, бараа	4.9	104.3	101.8	100.4
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	3.6	108.6	102.1	100.3
Тээвэр	14.4	104.8	98.9	99.7
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.4	101.0	100.0	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	3.1	117.3	110.5	108.9
Боловсролын үйлчилгээ	4.8	105.6	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	3.0	108.8	105.7	101.7
Бусад бараа, үйлчилгээ	5.4	105.9	103.2	100.6

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 6 дугаар сард өмнөх оны мөн үеэс 8.1 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 10.8 хувь (мах, махан бүтээгдхүүний дэд бүлгийн үнэ 31.6 хувь, согтууруулах бус ундааны дэд бүлгийн үнэ 5.8 хувь, сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөгний дэд бүлгийн үнэ 1.0 хувь), согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 3.8 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 9.8 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 4.8 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 8.8 хувь (цахилгаан, хийн болон бусад түлшний дэд бүлгийн үнэ 10.2 хувь), эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 8.6 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 6 дугаар сард өмнөх оны эцсээс 4.9 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 14.8 хувь (мах, махан бүтээгдэхүүн 40.9 хувь), хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 3.6 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 2.2 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 6 дугаар сард өмнөх сараас 0.7 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 0.6 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 0.7 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 0.2 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Зураг 2. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс (өмнөх оны 12 дугаар сар =100%), хувь



Хүснэгт 4. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, жил бүрийн 6 дугаар сард, хувь

Огноо	Бараа, үйлчилгээ	Улс	Улаанбаатар	Баруун бүс	Хангайн бүс	Төвийн бүс	Зүүн бүс
	Ерөнхий индекс	101.2	101.2	98.9	102.0	101.5	101.7
2016 VI	Бараа	99.7	99.5	97.3	101.0	100.2	100.3
	Үйлчилгээ	105.9	105.7	104.9	105.9	107.0	107.6
	Ерөнхий индекс	103.4	103.5	103.6	103.1	103.1	103.3
2017 VI	Бараа	103.7	103.8	103.5	103.6	103.6	103.3
	Үйлчилгээ	102.6	102.9	104.1	101.5	101.1	103.1
	Ерөнхий индекс	107.2	108.0	107.9	105.3	106.9	105.0
2018 VI	Бараа	108.1	108.8	109.5	105.8	107.9	105.9
	Үйлчилгээ	104.6	105.8	102.3	103.4	103.0	101.5
	Ерөнхий индекс	108.1	109.6	105.6	106.8	105.7	108.4
2019 VI	Бараа	108.5	110.1	105.1	107.3	106.4	109.4
	Үйлчилгээ	106.8	108.1	107.6	104.8	102.7	104.0

Хэрэглээний үнийн индексийг бараа болон үйлчилгээний бүлгээр задалж 2018 оноос бүсийн хэмжээнд тооцож эхэлсэн. 2016 оны 6 дугаар сард үйлчилгээний үнийн өсөлт түлхүү явагдаж байсан бол 2019 оны 6 дугаар сард бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт түлхүү явагдаж байгаа нь дээрх хүснэгтээс харагдаж байна.

Улаанбаатар хотод барааны үнийн өсөлт 10.1 хувь, үйлчилгээний үнийн өсөлт 8.1 хувь гарсан нь бусад бүсүүдээс хамгийн өндөр үзүүлэлт болж байна (Хүснэгт 4).


Хүснэгт 5. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулснаар, 6 дугаар сард, хувиар

Бүс, аймаг	2018 VI	2019 VI
Ерөнхий индекс	107.2	108.1
Баруун бүс	107.9	105.6
Баян-Өлгий	106.6	106.4
Говь-Алтай	105.7	106.0
Завхан	107.5	103.7
Увс	111.1	107.1
Ховд	108.8	104.1
Хангайн бүс	105.3	106.8
Архангай	104.6	108.0
Баянхонгор	109.6	106.6
Булган	104.3	105.1
Орхон	105.3	107.4
Өвөрхангай	105.7	107.6
Хөвсгөл	103.5	105.1
Төвийн бүс	106.9	105.7
Говьсүмбэр	105.4	106.9
Дархан-Уул	105.7	107.6
Дорноговь	104.5	106.3
Дундговь	105.9	105.5
Өмнөговь	110.3	105.5
Сэлэнгэ	107.7	104.3
Төв	107.5	105.0
Зүүн бүс	105.0	108.4
Дорнод	103.3	108.9
Сүхбаатар	106.2	107.1
Хэнтий	105.8	108.7
Улаанбаатар	108.0	109.6

Аймгуудад хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 6 дугаар сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад бүх аймгуудад 3.7-9.6 хувиар өссөн байна. Үнийн өсөлт Улаанбаатар хотод 109.6 хувьд хүрсэн нь хамгийн өндөр өсөлт болж байна (Хүснэгт 5).

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 6 дугаар сард өмнөх сараас Баянхонгор, Баян-Өлгий, Завхан, Хөвсгөл, Дорноговь, Өмнөговь, Сүхбаатар аймгуудад 0.1-0.7 хувиар өсөж бусад аймагт 0.1-1.4 хувиар буурсан байна. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 6 дугаар сард Сэлэнгэ аймагт 1.4 хувиар буурч, Өмнөговь, Дорноговь аймагт 0.7 хувиар өссөн нь хамгийн их байна (Зураг 3).

Зураг 3. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, хувь, аймаг, нийслэлээр, 2019 оны 6 дугаар сард (өмнөх сар= 100%)



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ Улаанбаатар хотод 2019 оны 6 дугаар сард өмнөх сараас 1.4 хувь, өмнөх оны эцсээс 5.4 хувь, өмнөх оны мөн үеэс 9.6 хувиар өслөө.


Улаанбаатар хотод хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 6 дугаар сард өмнөх оны мөн үеэс 9.6 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 11.7 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн дүн 16.0 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 11.7 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 4.1 хувь, тээврийн бүлгийн үнэ 3.4 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Улаанбаатар хотод хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 6 дугаар сард өмнөх оны эцсээс 5.4 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 16.2 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 5.1 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 2.1 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.


Улаанбаатар хотод хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 6 дугаар сард өмнөх сараас 1.4 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 2.7 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 0.9 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 0.3 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Улаанбаатар хотод 2019 оны 6 дугаар сард өмнөх сараас хэрэглээний сагсны 344 нэрийн бараа, үйлчилгээний 32.6 хувь буюу 112 бараа, үйлчилгээний үнэ өсөж, 11.3 хувь буюу 39 бараа, үйлчилгээний үнэ буурч, 56.1 хувь буюу 193 бараа үйлчилгээний үнэ өөрчлөлтгүй байв. Судалгаанд сонгогдсон хүнсний 100 нэрийн барааны 52 нэрийн барааны үнэ нэмэгджээ.

Зураг 4. Мах, махан бүтээгдэхүүний үнийн улсын индекс, хувиар, (өмнөх оны 12 дугаар сар = 100%)




2019 оны 6 дугаар сард мах махан бүтээгдэхүүний үнэ өмнөх оны эцсээс 40.9 хувиар өссөн байна. Үүнд үхрийн махны үнэ 42.3 хувь, хонины ястай махны 53.1 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.



Зураг 5. Мах, махан бүтээгдэхүүний оролцооны түвшин, 2019 оны 6 дугаар сард


2019 оны 6 дугаар сард оны эцсээс инфляц 4.9 хувиар өссөн бөгөөд 3.0 нэгж буюу 61.8 хувь нь мах, махан бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс шалтгаалсан байна.

Зураг 6. Улаанбаатар хотод зарагдаж буй үхрийн цул махны дундаж үнэ, сараар, төгрөгөөр




Улаанбаатар хотод зарагдаж байгаа үхрийн цул махны дундаж үнэ 2019 оны 6 дугаар сард 14 230 төгрөгийн үнэтэй байгаа нь 2016 оны 6 сараас 43.1 хувь, 2017 оны 6 сараас 53.0 хувь, 2018 оны 6 сараас 35.1 хувиар өссөн байна.

Зураг 7. Улаанбаатар хотод зарагдаж буй үхрийн ястай махны дундаж үнэ, сараар, төгрөгөөр




Улаанбаатар хотод зарагдаж байгаа үхрийн ястай махны дундаж үнэ 2019 оны 6 дугаар сард 11 702 төгрөгийн үнэтэй байгаа нь 2016 оны 6 сараас 38.7 хувь, 2017 оны 6 сараас 48.1 хувь, 2018 оны 6 сараас 34.0 хувиар өссөн байна.

Зураг 8. Улаанбаатар хотод зарагдаж буй хонины ястай махны дундаж үнэ, сараар, төгрөгөөр




Улаанбаатар хотод зарагдаж байгаа хонины ястай махны дундаж үнэ 2019 оны 6 дугаар сард 10 432 төгрөгийн үнэтэй байгаа бөгөөд 2016 оны 6 сараас 48.4 хувь, 2017 оны 6 сараас 55.7 хувь, 2018 оны 6 сараас 38.8 хувиар өссөн байна.

Зураг 9. Бензин, түлшний үнийн индекс, хувь, 2016-2019 он (өмнөх оны 12 сар=100%)



2019 оны 6 дугаар сарын байдлаар бензин, түлшний үнэ өмнөх оны эцсээс 1.7 хувь, өмнөх сараас 0.1 хувиар буурчээ.

Зураг 10. Улаанбаатар хотод зарагдаж байгаа АИ-92 бензиний дундаж үнэ, сараар, төгрөгөөр



2019 оны 6 дугаар сард АИ-92 бензиний дундаж үнэ 1 886 байгаа нь 2016 оны 6 сараас 23.7 хувь, 2017 оны 6 сараас 15.7 хувь, 2018 оны 6 сараас 9.0 хувиар тус тус өссөн байна.